

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№19/496

ШУС, НУС

2018

**МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ТЕЛЕВИЗИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН**  
**НЭВТРҮҮЛГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Г.Мэндхүү\*, У.Мандаа\*\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

\*\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант (ӨМӨЗО)

**Түлхүүр үг:** сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл, аялал жуулчлал, телевиз, аялал жуулчлалын нэвтрүүлэг, соёл, түүх.

**А**ялал жуулчлал нь орчин цагт хурдацтай хөгжиж буй салбар бөгөөд хүний ертөнцийг үзэх үзэл, асуудалд хандах хандлагад нөлөөлдөг. Аялал жуулчлалын тухай нэвтрүүлэг нь бусад улс орны хөгжил, хүн ардынх нь аж амьдралын хэв маягийг үзэгчдэд танилцуулдаг чухал цонх болсон. Хүмүүс “Аялал жуулчлал бол өөрийн хаширтлаа суусан газраасаа өөр хүний хаширтал суусан газарт очихыг хэлнэ” хэмээн ярьдаг. Энэхүү хэллэг нь хэдийгээр утга далд явцуу мэт боловч ямар нэгэн ёс заншил цаанаа агуулсан мэт. Аялал жуулчлал бол аливаа улс орны соёлыг нь мэдэрч ойлгох тавцан ба өөрийн сэтгэхүйн хэв маяг, сонсох, харах, хүрэх, үнэрлэх зэрэг мэдрэмжээр дамжиж жуулчны өөрийн өвөрмөц соёл буюу аялж буй газрын соёл түүхтэй харилцан солилцох, адилтгах, суралцах түүнд нөлөөлөх үйл явц юм. Аялал жуулчлалын урьдач нөхцөл бол шинэ

соргог, үл мэдэх зүйлээ хайж хөөцөлдөхөд байдгаас одоогийн нийгмийн аль талын хөгжлийг дагаж буйгаас хамаарч хүмүүсийн амьдралын төвшин дээшилж, аялах нь хүмүүсийн амарч зугаалах нэгэн төрлийн арга хэлбэр болсон юм. Аялал жуулчлал хурдацтай хөгжиж байгаатай зэрэгцэн аяллын тухай нэвтрүүлэг ч үзэгчдийн сонирхлыг их татах болжээ. Телевиз нь аяллын өв соёлыг түгээх хадгалах гол хүчин зүйл болж чаддаг. Аяллын хөгжлийн ид зангилааны эрин үед, телевизийн аяллын нэвтрүүлэг нь тохирсон цаг үедээ үзэгчдийн хүртээлд хүрч асар түргэн хөгжсөн юм.

Телевизийн аяллын нэвтрүүлэг нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн хувьд аян замын тэмдэглэлд хамааруулж авч үзэж болно. Зохиогч гадаад улс орон, эх орны өнцөг буланаар аялж явах, томилолтоор ажиллах, явцад ажиглагдсан шинэ сонин зүйл, тэдгээр орны хөгжил цэцэглэлт, ард түмний аж байдал, зан заншил, нийгмийн байгууллын онцлог, байгалийн өвөрмөц үзэгдэл үйл явдал зэргийг уншигчдад сонирхуулах танин

мэдүүлэх зорилгоор бичигдсэн тэмдэглэлийн дотоод хэлбэр мөн.<sup>1</sup>

Аялал жуулчлалын нэвтрүүлэг нь хөтлөгчөөс зурагт дуу шингээлт зэргээр дамжуулан тухайн нутаг орныхоо байгаль, уул ус, эх баялаг, түүх соёл, амьдралын байдал, зан үйл, идээ ундаа зэрэг өвөрмөц мөртлөө гайхалтай сайхан зүйлсийг сурталчлан ухуулга хийх үйлчилгээний тавцан болоод асуудлыг илрүүлж шийдвэрлэх арга юм. Энэ нь тухайн улс орон өөрийгөө таних үйл явц төдийгүй өөрийгөө бусдад таниулах сайхан завшаан юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улс болон БНХАУ-ын телевизийн салбарт аялал жуулчлалын нэвтрүүлгийн нэр төрөл олширчээ. Энэ өгүүлэлд нэр дурдсан хоёр улсын телевизийн аялал жуулчлалын нэвтрүүлгийг харьцуулан ажиглалт хийв.

**Б**НХАУ болон Монгол Улсад аялал жуулчлалын нэвтрүүлгийн олон нэр төрөл бий. Жишээ дурдвал Хятадын "Аянчин" /xing zhe/, "Холын нутаг" /yuan fang de jia/, "Аялал жуулчлалын 365 өдөр" /lv xing 365/, "Үзэсгэлэнт дэлхий" /shi jie zheng mei li/ зэрэг нэвтрүүлгийг дурдаж болно. Монголын аялал жуулчлалын сэдэвт нэвтрүүлгүүдээс дурдвал "Аяллын цаг", "Үүргэвчтэй аялал", "42 размерын жим", "Төмөрбаатартай хамт Япон орноор", "Гайхамшигт аялал" гэх мэт. Эдгээр нэвтрүүлгүүдээс нэлээд олон үзэгчтэй аяллын нэвтрүүлгийг сонгон харьцуулан судаллаа.

*Хятад улсын "Аянчин" нэвтрүүлэг.* БНХАУ-ын Хайнань мужийн "The Travel Channel" телевиз 2004 оны долдугаар сараас "Аянчин" нэвтрүүлгийг бэлтгэдэг болсон юм. Баримтат кино хэлбэрээр долоо хоног бүрийн мягмар-бямба гарагт 21:30 цагаас эхэлж 30 минутын хугацаатай

үргэлжилдэг. Өнөөг хүртэл нийт 1462 бүлэг гарсан байна. "Аянчин" бол аялж явах ба асуудлыг илрүүлэхийг гол зорилгоо болгож аялагч хувь хүний оюун ухаан ур чадвараа харуулахын зэрэгцээ аялж буй газрын түүх соёлын хэв маягийг гол болгосон цуврал нэвтрүүлэг юм. Энэ нэвтрүүлэг нь аялал жуулчлалын дундаа сайн сайхан өнгө үзэмж, идээ ундаа, соёл дурсгалтай танилцаж түүхийн дурсгал болон нэрт хүмүүсийн үлгэр домгийг хайдаг. Тус нэвтрүүлэг нь бусад ижил төрлийн нэвтрүүлгээс өөр байдаг нь Аянчин хувь хүний хүмүүнлэгийн шинжтэй бөгөөд бизнесийн ашиг сонирхлын шинжгүй. Хувь хүний аяллаар ертөнцийн сайн сайхныг илрүүлж олон түмэнд хуваалцахаар үндэслэлээ болгодог. Үүнийг нэвтрүүлэг гэж хэлэхийн оронд хувь хүний өдрийн тэмдэглэл гэж ойлгосон ч болно. Аялагч зурагтаар өөрийн ойр хавьд үүсэж байгаа нийгмийн зөв энергийг уламжилж бусдын өмнөөс үйлчилж явсан хүмүүс ямар нэгэн жижигхэн үйл ажиллагаагаар дамжиж аяллынхаа шинэ сэдэв болгож цаг ямагт дурандаа буулгаж байдаг. Аливаа аялал жуулчлалын эх сурвалж амьдралаас эхтэй байдаг. Иймээс "Аянчин" нэвтрүүлэг үзэгчдийн таашаалд нийцдэг. Хятадын телевизийн аяллын нэвтрүүлгийн өөр нэг жишээг татая. Өвөр Монголын Шилийн гол аймгийн телевиз 2014 оны 12 дугаар сарын 14-нд "Шинэ Хөдөө" нэвтрүүлгийн хамт олон Хятад улсын Юнань мужийн Юй Ши хотын Шин Мэн Шянд очиж 13-р удаагийн Монголчуудын наадмын тухай нэвтрүүлэг хийжээ. "Шин Мэн Шян бол Юнань мужийн цорын ганц Монголчуудын төвлөрсөн сум. Нийт 5000 орчим оршин суугчтай. 1253 онд Хубилайн цэрэг өмнө оронд дай-

лаад Юнань мужийг эзэлжээ. Хожим Юан гүрэн мөхсөний дараа 1381 онд Жү Юайн Жан 30 түмэн цэргийг удирдан өмнөд зүгт дайлж Монголын цэрэг Юнань дахь ноёрхлоо дуусгасан. Дайны дараа ялагдсан Монголын морьт цэргийн үр хойч нь энэ хэсэг газраар нуугдан амьдарч 700 гаруй жилийн урт удаан түүхтэй болсон. Иймээс өнөөг хүртэл улс газар орны Монгол хүмүүс олон арвин дээдсээсээ уламжилж үлдсэн Монголын зан заншил тэд нарын бие дээрээс илэрч байдаг” хэмээн эхлүүлжээ. Энэ удаагийн аялал жуулчлалын нэвтрүүлэг нь хүмүүсийн сонирхол болон анхаарлыг татахын тулд нэвтрүүлгийг маш сонирхолтой эхлүүлсэн. Сэтгүүлчид уул ус, өнгө үзэмж, зан заншлыг танилцуулахдаа амьдрал ахуй байдалтай нь уялдуулж соёл түүхийн талаас илүү шинжилжээ. Жишээлбэл, идээ ундааны соёлыг танилцуулахдаа идээний талаарх соёл түүхийн он удаан жилийн явцыг өнгөрснөөс нь, бүр соёл хэл хэллэг бүрдсэнээс нь эхлэн тайлбарласан нь сонирхолтой болгожээ.

Ярилцах арга хэлбэрээр энэ нутгаас гарсан Хятадын гавьяат нисгэгч, мөн ч цорын ганц нисгэгчийн гавьяа тэмдгийг авсан монгол хүнтэй ярилцлага хийсэн. Энэ хүний өөрийн нэг насны тэмцэл чармайлт боловсролор дамжуулж монгол хүний боловсрол суртал хатуужилтай шаргуу үзэл санаа, зан заншлаа уламжилж сурталчлахын төлөө дэлгэрэнгүй ярилцжээ. Сурган хүмүүжлийн талаас бид сургуулийн хичээлийн өрөөнд хүүхдүүдтэй хамт 45 минутын дуу хөгжмийн хичээл орж багш нь хүүхдүүддээ хэрхэн монгол дуу зааж өгч байгаа үзэгдэл байдлын үнэн бодит зураг дүрсээр шингээж дээдсээс уламжилж

ирсэн үндэстнийхээ өв соёлоо хамгаалж уламжилж байгааг нь тодруулжээ. Энэ нь бидэнд сэдэл өгч сэтгэл хөдөлгөсөн иймэрхүү үйл ажиллагаа нь монголчуудад бахархал төрүүлсэн.

**Н**эвтрүүлгийн сонирхолтой цэнгээнт чанарыг дээшлүүлэхийн тулд уран бүтээлчид нь нутаг орны хүмүүсийг дагаж тариан газарт нь очиж тэдэнтэй хамт тариа тарьж амьдралд нь ойртож үзсэн юм. Яагаад Монгол хүн байж тариа тарьж, загас агнах болсон тухай түүхийн соёлыг сэргээж чөлөөтэй ярилцлага хийсэн. Энэ нь голдуу хүмүүнлэгээр нэвтрүүлгээ хийж хүмүүс үзэхэд аятай цэнгээнт чанартай, хүмүүсийн сонирхлыг татаж чаддаг нэвтрүүлгийн дунд хөөр наргианаар дамжиж сурвалжлага хүлээн авагчийн сандарсан байдлыг тайвшруулж үзэгчид ч бас баяр хөөртэй хүлээж авдаг. Сэтгүүл зүйн бичлэгийн олон төрөл зүйлийг хослуулан хийсэн энэ нэвтрүүлэг хэлбэрийн хувьд нэлээн шинэлэг болж чадсан. Ингэснээр үзэгчид ба телевизийн харилцааг ойртуулж, олон түмэнд сонирхолтой шинэ мэдээлэл өгсөн юм. Газар орны түүх, соёл, үлгэр, домог гэх мэт арвин шинэ соргог сэдвийг танилцуулжээ. Аяллын соёлын яруу сайхныг үзэгчдэд уламжилж сурталчлах нь аялал жуулчлалын нэвтрүүлгийн гол үүрэг болох юм<sup>2</sup>.

Ялангуяа аялал жуулчлалын нэвтрүүлэгт агуулгаа үзэгчдэд хүргэх арга хэлбэр нь баримтат кино, тодруулга ярилцлага, танилцуулга; хөтлөгч, нэвтрүүлэг, студийн интерактив болон том хэлбэрийн чөлөөтэй яриа хийх зэрэг олон төрөл багтдаг. Аль ч хэлбэрийг ашигласан байж болно. Гол нь нэвтрүүлгийн арга хэлбэр дээрээ уян хатан олон янзын байх бөгөөд

агуулгын хувьд уялдан зохицсон байх хэрэгтэй.

*Монгол улсын “Аялалын цаг” нэвтрүүлэг.* Тус нэвтрүүлгийг Монголын Үндэсний Телевиз 1998 оноос эхлэн бэлтгэсэн. Нэвтрүүлгийн анхны дугаараар Бурхан Халдун уулын тахилгын тухай үзүүлжээ. Нийт 400 гаруй нэвтрүүлэг хийгдсэнээс жилд 40 гаруй нэвтрүүлэг бэлтгэдэг сонгомол аялал юм. Нэвтрүүлгийн хэв маяг нь орчин үеийн байдлаас шалтгаалснаас болж бага сага хэвшмэл байдаг. Зураг ая дуу найруулагчийн ар талын тайлбараар нэвтрүүлгээ бүтээж байсан. Гэвч агуулгын хувьд маш шинэлэг бодитой мөртлөө сонирхолтой байдаг учраас үзэгчдийн сэтгэлд ихээр нийцдэг.

**Э**нэ нэвтрүүлгийн гол зорилго нь дэлхийг Монголчуудад таниулах, Монголыг дэлхийд таниулах юм. Сэтгүүлч Г.Бадамсамбуу эрхлэн бүтээсэн “Аяллын цаг” нэвтрүүлэг бол тойрон аялахдаа газар орны түүхт соёл, шашин шүтлэг, зан заншил, өнгө үзэмж, хотын бүтээн байгуулалт зэрэг талаар судалгаа хийж давхар тайлбар хүргэдэг. Энэ нь үзэгчдэд танин мэдэхүйн чухал ач холбогдол үзүүлдэг. Зарим түүх соёлын талаар Монголтой харьцуулан адилтгадаг нь хүмүүсийн сонирхлыг болоод сэтгэхүйг ихэд татдаг хэдий ч нэвтрүүлэг бүтээх явцад олон асуудлууд гарсан гэх мэдээлэл байсан. Үүнд:

-Санхүүгийн дэмжлэг дутмаг байдаг учраас нэвтрүүлгээ үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байдаг. Г.Бадамсамбуу нэгэн ярилцлагадаа найз нөхдүүд нь санхүүгийн талаар их дэмжлэг үзүүлж байсан хэмээн хэлж байсан. Зарим газар очиж нэвтрүүлэг хийж чадахгүй

байгаа нь туйлын харамсалтай байна хэмээжээ.

-Тухайн үед тоног төхөөрөмж ба мэргэжлийн талаар арай хоцронгуй байсан. /Энэ нь нэвтрүүлгийн зураг авалтын талаар ярьж байгаа юм./

-Монголын нутаг орондоо нэвтрүүлэг хийхэд бага зэрэг асуудал тулгардаг. Яагаад гэвэл хөдөө орон нутгаар амьдарч байгаа хүмүүсийн соёлын хэм хэмжээ доор бас үндсэрхэг үзэл ихтэй учраас нэвтрүүлэг үзээд очсон аялагчдад сөрөг хандлага гаргадаг. Учир нь тэдний бодол санаанд ирсэн аялагчид газар нутгийг эвдэх буюу өвс ногоог нь гишгэж орчныг бохирдуулна гэж боддог учир нутгаа харамлаж хамгаалах сэтгэлээс нь үүдэлтэй. Нутаг орноо хөгжүүлж дэлхийд таниулах ухамсарт хараахан бэлэн бус байнгын илрэл юм. Ийм шалтгаануудын улмаас орон нутагт аялал жуулчлалын нэвтрүүлэг хийх нь бага сага хүндрэлтэй байдаг байсан.

Хятад, Монголын телевизийн аяллын нэвтрүүлгийн адил ба ялгаатай талууд: Хятад, Монгол аялал жуулчлалын нэвтрүүлгийн сэдэв агуулга тодорхой байдаг. Хэдийгээр үг хэллэг соёлын талаар адил бус боловч нэвтрүүлгийн зорилгын үүднээс авч үзвэл адил төсөөтэй тал их.

#### *Адил төсөөтэй талууд:*

-Аялж очсон газар орныхоо газар зүйн онцлог, хүн ам, эх байгаль, уур амьсгал, соёл заншил, түүхэн дурсгалт газар, нэрт хүмүүс, улс төрийн талаар товч танилцуулга хийж мөн өөрийн нутаг оронтойгоо эерэг ба сөрөг талын харьцуулалт хийж асуудлыг илрүүлэн шийдвэрлэх талаар санал зөвлөмжийг хүргэдэг.

-Тухайн газар орны техник технологи болон аж ахуйн хөгжлийн талаар дэлхийд үзүүлсэн үр нөлөө ач

холбогдлыг үзэгчдэд таниулж үзэгчдийн оюун ухааны мэдлэгийг өргөтгөдөг.

-Үзэгчдийнхээ нүд чих нь болж хүмүүсийн очих хүслийг сэргээж дур сонирхлыг татдаг. Аялал жуулчлалын нэвтрүүлэг нь аялж очсон газартаа сайн үр нөлөө хязгааргүй их үр ашгийг авчирдаг.

#### *Ялгаатай талууд:*

-Монголын аялал жуулчлалын нэвтрүүлэг нь эрх чөлөөтэй байдаг. Үүн дотроос улс төрийн тухай түүх соёлын талаар өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг. Зөвийг магтаж бурууг шударгаар шүүмжилдэг. Ихэнх аялал жуулчлалын нэвтрүүлэг хийж байгаа хүмүүст газар орны ямар нэгэн албан байгууллага болон санхүүгийн дэмжлэг бага байдаг учраас өндөр хөгжилтэй улс орноор аялж, тэдний соёл түүхтэй танилцах болон ахуй амьдрал орчин тойрон тэдний гайхамшигт газар оронд ойртож ойлгох боломж нь бага байдаг. Иймээс нэг улс орныг бүх талаас нь бүрэн гүйцэд танилцуулахад хязгаарлагдмал байдаг. Санхүүгийн шалтгаанаар техник төхөөрөмж хомс байдаг нь бүрэн гүйцэд агуулга бүхий зураглалт нэвтрүүлэг бэлтгэхэд нэг талын бэрхшээл болдог нь ойлгомжтой. Энэ нь цаашлаад нэвтрүүлгийн чанарт нөлөөлдөг.

-Хятадын аялал жуулчлалын нэвтрүүлэг нь үзэл санаа, агуулгын хувьд ялимгүй хязгаарлагдмал. Тодруулбал, Хятад улсын үндэсний эрх ашигт халдсан ба ард түмэнд эсрэг нөлөө үзүүлэх түүх соёл, улс төрийн бодол, намыг эсэргүүцсэн үг яриа, орчин үеийн муу муухай байдлыг харуулсан агуулгатай нэвтрүүлэг хийхийг хориглодог. Учир нь телевиз бол намын дуу хоолой болохоор улсын эрх ашгийг

хамгаалж дэлхийд үзүүлэх нөлөөг чухалчлан үздэг. Дотоодод аялал жуулчлалын нэвтрүүлэг хийхдээ тухайн газар орны сонин сайхныг сурталчилж аялал жуулчлалын хөгжилд хувь нэмрээ оруулдаг.

-Нэвтрүүлгийн чанар чансаа сайн байдгийн бас нэг шалтгаан нь албан байгууллага болон засгаас санхүүгийн дэмжлэг сайтай учраас дуу дүрс чанарын өндөр түвшний нэвтрүүлэг хийх боломжийг олгодог. Иймээс агуулга, сэдэв өргөн цар хүрээтэй байдаг бөгөөд үзэгчдийн оюун ухааны мэдлэгийн хэрэгцээ шаардлагыг хангахад их тусламж болдог.

-Нэвтрүүлэг хийх боломжгүй үед засгаас тусламж зохицуулалт хийж өгдөг. Ар талын дэмжлэгийн хүч маш ихтэй. Гадаад улс орон ч гэсэн Хятадын аялал жуулчлалын нэвтрүүлгийг дуртай хүлээж авдаг. Хятад бол аялал жуулчлалын том орон зай юм. Нэвтрүүлгийн дэлхийд үзүүлэх нөлөө их байдгаас тус газар орны аялал жуулчлалыг их хэмжээгээр хөгжүүлж улсын хөрөнгө орлогыг нэмэгдүүлэхэд их ашигтай байдаг.

-Хятад болон Монголын телевизийн аяллын нэвтрүүлгийн ур хийц, уран бүтээлчдийн ур чадвар, судалгаа, мэдлэгийн талаас их зөрүү ялгаа байхгүй.

**И**йнхүү харьцуулан үзээд аяллын нэвтрүүлгийг улам сайжруулах ямар бололцоо байгааг дурдая.

Аяллын нэвтрүүлэг нь үзэгчдийн оюуны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Өдгөө аялал жуулчлалын нэвтрүүлгийг хүлээн авч байгаа хүмүүс улам нэмэгдсээр байна. Тэд одоо энгийн аялагчаас мэргэжлийн аялагч болон хувирч байна. Хүмүүсийн соёлын түвшин дээшилж уул, ус өнгө үзэмжээс гадна цаад

талын түүх соёлыг илүү анхаарах болсон байна. Үзэгчдийн гоо сайхны ухамсар дээшилж нэвтрүүлгийн чанар чансаанд ч улам өндөр шаардлага тавих болсон. Нэвтрүүлэг өвөрмөц онцлог, үнэн бодит соёлын агуулгагүйгээр одоогийн хүмүүсийн сонирхлыг татаж чадахааргүй болсон. Энэ шалтгаанаас болж үзэгчдийн тоо буурдаг. Бид эрх биш өөрийгөө сонор сэрэмжтэй байлгаж эртнээс шийдвэрлэх арга төслөө гаргаж бэлтгэлтэй байхын зэрэгцээ үзэгчдийн оюун ухааны хэрэгцээг хангах хэрэгтэй. Тэгвэл нэвтрүүлэг нь сая урт удаан оршин тогтнож чадна.

Газар орон өөр өөрийн онцлог шинжтэй байдаг.

Аялал жуулчлалын нэвтрүүлэг хэрхэн тухайн газар орныхоо түүх соёлыг харуулах утга агуулгыг сонирхолтой дамжуулж чадах нь нэвтрүүлгийн төсөөлөх чадвар болон илтгэх чадвар дээр илэрч байдаг. Газар орон өөр өөрийн соёл онцлогоо баримталж, дахин давтагдашгүй онцгой содон зүйлийг аяллын нэвтрүүлгээрээ үзүүлэх хэрэгтэй.

Нэвтрүүлэг хийхдээ олон зүйлийн хэв маягаар хийх хэрэгтэй. Одоо цагт аялал жуулчлалын нэвтрүүлэг хийж байгаа доорх гурван хэлбэр байна.

- Хамгийн анхны хэвшмэл арга хэлбэр гол нь ая дуу, хөтлөгчийн тайлбар ба зураг дүрстэй уялдуулах аргаар нутаг орны түүх соёл идээ ундаа зэргийг танилцуулдаг. Иймэрхүү арга хэлбэр

одоогийн цаг үед сонирхолгүй болсон. Нэг талаар иймэрхүү нэвтрүүлэг арга хэлбэрээ өөрчлөх хэрэгтэй. Нөгөө талаар камерыг бүрэн төгс ашиглаж зураг дүрсийг сайтар эмхтгэн дэглэх чадварыг дээшлүүлэх замаар нэвтрүүлгийн агуулгыг сайжруулах хэрэгтэй.

- Сонирхолтой хөгжөөнт цэнгээнт хэлбэрээр аяллын нэвтрүүлэг хийдэг нь өнөө цагт нэлээд дэлгэрч байгаа арга хэлбэр бөгөөд шинэ соргог сэдэлтийн шинжтэй. Энэ нь нэвтрүүлэгт оролцогчдын хөгжөөнтэй цэнгээнтэй байдлаар дамжиж, үзэгчдийн сэтгэлд хүрч улмаар тухайн газар орны соёл

түүх ба үлгэр домог онцлог бүхий зүйлсийг сурталчилахад оршино. Гэвч заримдаа үзэгчдийн анхаарлыг татахын төлөө хөгжөөнт тал дээр илүү анхаарч аяллын нэвтрүүлгийн гол агуулгыг алдагдуулах талтай. Хөгжөөнтэй тал болон мэдлэгийн шинжийг хослуулж чадвал иймэрхүү нэвтрүүлгийн арга хэлбэр нь нэлээд үр өгөөжтэй.

- Газар дээр нь зураг авалт хийж түүнийгээ эфирт шууд дамжуулах арга хэлбэрийн нэвтрүүлэг бас байдаг. Ийм нэвтрүүлгийн гол зорилго нь аялж буй газрын тухайн нөхцөл байдлыг шууд эфирт нэг цаг үед дамжуулан шууд эфирийн танхимд буй нэвтрүүлэгт оролцогчид өөрсдийн санал бодлыг хуваалцдаг. Энэ төрлийн нэвтрүүлэг нь телевиз

«

*Хүмүүсийн соёлын түвшин дээшилж, уул ус, өнгө үзэмжээс гадна цаад талын түүх соёлыг илүү анхаарах болсон. Үзэгчдийн гоо сайхны ухамсар дээшилж нэвтрүүлгийн чанар чансаанд ч улам өндөр шаардлага тавих болжээ. Нэвтрүүлэг өвөрмөц онцлог, үнэн бодит соёлын агуулгагүйгээр одоогийн үзэгчдийн сонирхлыг татаж чадахгүй*

»

үзэгчдэд бусдын бодлыг сонсож өөрийнхтэйгөө харьцуулж үнэлэлт дүгнэлт хийх боломж олгодог. Гэхдээ энэ нь хэтэрхий хувь хүний үзэл бодлыг хөөцөлдсөн шинжтэй байдаг учраас тухайн газар орны соёл түүх мэдлэг мэдээллийг багасгадаг. Энэ хойшдоо нэвтрүүлгийн чанар чансааг бууруулж мэднэ.

**Ө** нөөдөр аялал жуулчлалын нэвтрүүлэг улам ихээр хүмүүсийн анхаарлыг татсаар байна. Аялал жуулчлалын нэвтрүүлэг хөгжлийн явцдаа байхад харин зарим нэвтрүүлгийн чанар чансаа муудаж хүмүүсийн санаанд хүрэхгүй болж сайн тунгааж бодох хэрэгтэй болсон байна. Одоогийн нэвтрүүлэг хүмүүст хоосон өнгө үзэмж, уул усыг сонирхуулах аялал цэнгэлийн тухай мэдээ гаргах, ямар арга хэлбэрээр нэвтрүүлэг гаргах нь тийм чухал биш. Харин аялал жуулчлалын нэвтрүүлгээр дамжуулж үзэгч хувь хүний мэдлэг хуримтлуулах хүсэл шаардлага ба хувь суртал оюун ухааны хэрэгцээг хангах юм. Соёлын яруу сайхныг үзэгчдэд уламжлах нь аялал жуулчлалын нэвтрүүлгийн амин сүнс болно<sup>3</sup>.

Үзэгчид бол аялал жуулчлал нэвтрүүлгийн гол үйлчлүүлэгч мөн. Нэвтрүүлгээ найруулж үйлдэхэд үзэгчдийн хэрэгцээг хангах үүднээс бодолхийлэх хэрэгтэй. Ооогийн соёлын төвшин дээшилж буй цаг үед үзэгчид агуулгын хувьд өндөр шаардлага тавьдаг болсон бөгөөд үзэсгэлэнт газар орныг сонирхож үнэлэхийн зэрэгцээ газар нутгийн цаана далдлагдаж байгаа соёлын ач холбогдлыг ойлгохыг зорьдог болсон. Энэ нь үзэгчдийн гоо сайхны мэдрэмж, соёлын чанарыг хөгжүүлэх шинэ хандлага юм. Нэвтрүүлгээ найруулж үйлдэхдээ харааны болон сонсголын нөлөөллийг анхаа-

рахаар барахгүй, камераар бичлэг хийж байгаа зургийнхаа чанарыг баталж, янз бүрийн үзэсгэлэнт газруудад агуулагдаж буй соёлыг олон талаас илрүүлэн танилцуулж, соёлын хүчээр үзэгчид бүхний үзэл бодлоо санаа сэтгэлийг нөлөөлнө. Иймээс телевиз идэвхтэйгээр сувгаа сурталчилж, агуулгаа шинэчилж, улам сайн үзэгчид бүхэндээ үйлчлэх хэрэгтэй.

#### Ишлэл

1. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2018. х.29.
2. Чен Хуан. телевизийн аяллын нэвтрүүлгийн хөгжилтийн байдал ба арга хэмжээ//Southeast Communication. China, Fu zhou.,2013.№10.х.88-89. (东南传播)
3. Жиан Жи Мин. Телевизийн аяллын нэвтрүүлгийн инноваци ба хөгжлийн судалгаа// Science&Technology for China's Mass Media. China. Beijing., 2013. №20. х.51-53.(中国传媒科技)

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2018. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
3. Чэн Хуан. 2013. (20). Southeast Communication. China., Fu zhou.
4. Жан ЖИ Мин.2013.(20). Science & Technology for China's Mass Media. China., Beijing

#### Резюме

Статья посвящена к сравнительному анализу телепередач о путешествии монгольского и китайского телевидения. В статье дается характеристика теле передач и анализируется композиция, тема и мастерство творческих групп. А также автор сравнивает исходство и различия телепередач двух стран.